

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2009 оны 11 дүгээр
сарын 23-ны өдөр

№ 253

Улаанбаатар хот

“Харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй болон
бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх журам”-ыг батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 36.1, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

3. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2010 оны эхний хагас жилд багтаан Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн албатай хамтран сургалт зохион байгуулахыг Эрх зүйн хэлтэс /О.Батбилэг/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХЭЭС СЭРГИЙЛЭХ,
ХАРИЛЦАГЧИЙГ ТАНЬЖ МЭДЭХ, СЭЖИГТЭЙ БОЛОН БЭЛЭН
МӨНГӨНИЙ ГҮЙЛГЭЭГ МЭДЭЭЛЭХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэхэд харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй гүйлгээг илрүүлэх, сэжигтэй гүйлгээний болон бэлэн мөнгөний гүйлгээний тайланг Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албанд дамжуулахтай холбоотой Санхүүгийн зохицуулах хороонд харьяалагдах мэдээлэх үүрэгтэй этгээдийн үйл ажиллагаа, харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журамд дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.2.1. “Санхүүгийн зохицуулах хороонд харьяалагдах мэдээлэх үүрэгтэй этгээд гэж Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1-д заасан дараах этгээдийг:

- 1.2.1.1. Банк бус санхүүгийн байгууллага;
- 1.2.1.2. Даатгалын компани;
- 1.2.1.3. Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага;
- 1.2.1.4. Хадгаламж, зээлийн хоршоо;

1.2.2. “Сэжигтэй гүйлгээ” гэж мөнгөний гарал үүсэл, эцсийн хүлээн авагч нь тодорхой бус, эсхүл мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх санхүүгийн хяналтын механизм бүрдүүлээгүй улсаар дамжуулан хийсэн, түүнчлэн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэж үзэж байгаа гүйлгээг,

1.2.3. “Бэлэн мөнгөний гүйлгээ” гэж үндэсний болон гадаад улсын мөнгөн тэмдэгт, түүнчлэн олон улсын төлбөр тооцоонд түгээмэл хэрэглэгддэг чек, вексель, үнэт цаас ашиглан хийсэн гүйлгээг,

1.2.4. “Сэжигтэй гүйлгээний тайлан” гэж сэжигтэй гүйлгээ, түүнийг хийж гүйцэтгэсэн этгээдийн тухай мэдээллийг агуулсан Монголбанкнаас баталсан маягтын дагуу мэдээлэх үүрэгтэй этгээдээс Санхүүгийн мэдээллийн албанд ирүүлэх баримт бичгийг;

1.2.5. “Бэлэн мөнгөний гүйлгээний тайлан” гэж бэлэн мөнгөний гүйлгээний тухай мэдээллийг агуулсан, Монголбанкнаас баталсан маягтын дагуу мэдээлэх үүрэгтэй этгээдээс Санхүүгийн мэдээллийн албанд ирүүлэх баримт бичгийг,

1.2.6. “Санхүүгийн мэдээллийн алба” гэж Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 16 дугаар зүйлд заасныг,

1.2.7. “Харилцагч” гэж хуулиар олгосон төрөл бүрийн үйлчилгээг Мэдээлэх үүрэгтэй этгээдээс авч байгаа хувь хүн, хуулийн этгээдийг,

1.2.8. “Гүйлгээг түдгэлзүүлэх” гэж сэжигтэй гүйлгээний талаарх мэдээллийг шалгах зорилгоор Санхүүгийн мэдээллийн албанаас гаргасан шийдвэрийн дагуу тухайн гүйлгээг түр зогсоохыг,

1.2.9. “Гүйлгээ” гэж хөдлөх, үл хөдлөх хөрөнгө, бэлэн мөнгө, үнэт цаас, зээл, өр болон санхүүгийн бусад хэрэгслийг бусдад шилжүүлэх, хүлээн авах, худалдах, худалдан авах, зээлийг эргэн төлөх, дүрмийн санд хөрөнгө оруулах, өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх, хадгаламжийн болон харилцах данс нээлгэх, дансандаа бэлэн мөнгө хийх, даатгалын хураамж төлөх, даатгалын нөхөн олговор олгох, гадаад давхар даатгалын хураамж төлөх, валют худалдах болон худалдан авах зэрэг мэдээлэх үүрэгтэй этгээдийн Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрсөн үйлчилгээг хэлнэ,

1.2.10. “Харилцагчийн талаарх мэдээллийг шалгах” гэж харилцагчийг таньж мэдэх, харилцагчийн мэдээллийг үнэн зөв бүртгэх, зорилгоор харилцагчийн албан ёсны бичиг баримт (иргэний үнэмлэх, гадаад паспорт)-ыг үзэхийг,

1.2.11. “Харилцагчийн тухай албан ёсны бичиг баримт” гэж тухайн харилцагч хувь хүний овог, нэр, төрсөн эсхүл байгуулагдсан он, сар, өдөр, баримтын дугаар бүхий төрийн байгууллагаас олгосон хугацаа нь хүчинтэй бичиг баримт (иргэний үнэмлэх, гадаад паспорт, аж ахуйн бүртгэлийн гэрчилгээ)-ын эх хувийг,

ХОЁР. ХАРИЛЦАГЧИЙГ ТАНЬЖ МЭДЭХ ШААРДЛАГА

2.1. Мэдээлэх үүрэгтэй этгээд нь харилцагчийг таньж мэдэх зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрөгдсөн үйлчилгээ үзүүлэхийн өмнө дараах мэдээллийг харилцагчаас гаргуулж авна:

2.1.1. Харилцагч нь иргэн бол түүний эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа хаяг, регистрийн дугаар, холбоо барих утасны дугаар,

2.1.2. Харилцагч нь хуулийн этгээд бол түүний нэр, албан ёсны хаяг, улсын бүртгэлийн болон татвар төлөгчийн дугаар, харилцах утасны дугаар, төлөөлөн үйл ажиллагаа явуулах эрх бүхий этгээдийн нэр, хаяг,

2.1.3. Мэдээлэх үүрэгтэй этгээд харилцах, хадгаламж, гишүүнчлэл эсхүл зээлийн данс нээсэн, гэрээ байгуулсан этгээд нь иргэн бол түүний иргэний үнэмлэхний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, хуулийн этгээд бол түүний улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, хувь нийлүүлэгч, удирдлагын талаарх дэлгэрэнгүй танилцуулга,

2.1.4. Гүйлгээний утга, хийгдсэн гэрээ, хүлээн авагчийн тухай мэдээлэл,

2.1.5. Бусдын өмнөөс гүйлгээ хийж байгаа тохиолдолд төлөөлүүлж байгаа этгээдийн талаарх мэдээлэл;

2.1.6. Бэлэн бус шилжүүлэг хийсэн этгээдийн тухай мэдээлэл.

2.2. Мэдээлэх үүрэгтэй этгээд нь 20 сая төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/ буюу түүнээс дээш үнийн дүнтэй тэнцэх гадаад валютын арилжааны гүйлгээ хийхийн өмнө харилцагчаар энэ журмын 2.1-д заасан мэдээллийг гаргуулж авна. Харин 20 сая төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/-өөс доош валютын арилжаа хийх бүрт арилжаанд оролцож буй харилцагчаар овог, нэр, холбоо барих утас, арилжааны мөнгөн дүнг тусгай маягт бөглүүлж, маягтын хувийг өөртөө хадгална.

2.3. Мэдээлэх үүрэгтэй этгээд нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1-д заасны дагуу дараахь тохиолдолд харилцагчийн талаарх өмнө нь авсан мэдээллийг шалгах үүрэгтэй:

2.3.1. Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрөгдсөн 20 сая төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/ буюу түүнээс дээш үнийн дүнтэй гүйлгээ хийж санхүүгийн үйлчилгээ үзүүлэхийн өмнө,

2.3.2. Хоорондоо холбоо бүхий хэд хэдэн удаагийн гүйлгээний тус бүрийн үнийн дүн нь 20 сая төгрөгөөс бага боловч нийт үнийн дүн нь 20 сая төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/ буюу түүнээс дээш үнийн дүнтэй бөгөөд энэхүү гүйлгээ нь энэ журмын 2.2-т заасан мэдээллийг гаргаж өгөхөөс зайлсхийх зорилго агуулсан гэж үзэх үндэслэл байгаа бол,

2.3.3. Харилцагчийн талаар өмнө авсан мэдээллийн үнэн зөв эсэхийг шалгах шаардлагатай бол,

2.3.5. Гадаад төлбөр тооцооны гүйлгээ хийхийн өмнө,

2.3.6. Тухайн харилцагчийг буюу гүйлгээг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай холбоотой гэж үзэх бусад үндэслэл байгаа бол,

2.3.7. Давхар даатгалын хураамж төлөхийн өмнө,

2.4. Харилцагчийн мэдээлэх үүрэгтэй этгээдэд өгсөн мэдээлэл буруу, ташаа болох нь тогтоогдвол, мэдээлэх үүрэгтэй этгээд нь харилцагчаас энэ тухай тайлбар гаргуулах бөгөөд тайлбар өгөхөөс татгалзах, мэдээлэл нь хуурамч, үндэслэлгүй бол харилцагчид үйлчилгээ үзүүлэхээс татгалзана.

2.5. Харилцагч энэ журмын 2.2-т заасан мэдээллийг өгөхөөс татгалзвал данс нээх, гүйлгээ хийх, санхүүгийн бусад үйлчилгээ үзүүлэхээс татгалзах үүрэгтэй.

2.6. Мэдээлэх үүрэгтэй этгээд нь өөрийн харилцагчийн талаарх мэдээлэлд орсон өөрчлөлтийг бүртгэж, данстай харилцагчийн талаарх мэдээллийн багцыг 2 жил тутамд шинэчлэж байна.

2.7. Мэдээлэх үүрэгтэй этгээд нь гадаад орны ижил, төстэй байгууллагатай харилцаа тогтоохдоо тухайн байгууллагын талаарх энгийн мэдээллээс гадна дараахь мэдээллийг шалгана.

2.7.1. Тухайн байгууллагын бизнесийн мөн чанар

2.7.2. Тухайн улсын санхүүгийн хяналт шалгалт, зохицуулалтын байгууллага болон олон нийтийн мэдээллийн эх үүсвэрээс тухайн байгууллагын үйл ажиллагаа, нэр хүндийн талаар мэдээлэл авах,

2.7.3. Тухайн байгууллагын мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо, дотоод хяналтын хөтөлбөрийг судлах,

2.7.4 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд холбогдон шалгагдаж байсан эсэх талаар лавлагаа авах.

2.8. Мэдээлэх үүрэгтэй этгээд нь харилцагчийг таньж мэдэх шаардлагын хүрээнд өөрийн харилцагчдын эрсдэлийн төвшинг тогтоож өндөр эрсдэлтэй харилцагчийн данс, гүйлгээнд тусгайлан хяналт тавина.

ГУРАВ. СЭЖИГТЭЙ ГҮЙЛГЭЭГ МЭДЭЭЛЭХ

3.1. Мэдээлэх үүрэгтэй этгээд нь гүйлгээг мөнгө угаах, эсхүл терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай холбоотой гэж үзэх хангалттай үндэслэл байгаа бол эсхүл хууль тогтоомжид хориглоогүй мэдээлэл өгөхөөс илт татгалзсан харилцагчийн тухай сэжигтэй гүйлгээний тайланг бөглөж 24 цагийн дотор Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ. Мэдээлэх үүрэгтэй этгээд нь Санхүүгийн мэдээллийн албанаас ирүүлсэн сэжигтэй гүйлгээний жишээг сэжигтэй гүйлгээг таньж илрүүлэхэд ашиглана.

3.2. Мэдээлэх үүрэгтэй этгээдийн хэрэгжилт хариуцсан ажилтан нь тодорхой нэг гүйлгээ, харилцагчийн талаар Санхүүгийн мэдээллийн алба болон эрх бүхий байгууллагуудад мэдээлэл өгснийг байгууллагын болон мэргэжлийн нууц задруулсан гэж үзэх үндэслэл болохгүй.

3.3. Мэдээлэх үүрэгтэй этгээд нь сэжигтэй гүйлгээний тайлан, тэдгээрийн талаарх мэдээллийг өгсөн ажилтны нууцлал, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авч ажиллана.

3.4. Мэдээлэх үүрэгтэй этгээдийн удирдлага, ажилтан нь сэжигтэй гүйлгээний тайланг Санхүүгийн мэдээллийн албанд хүргүүлсэн талаар харилцагчдад ямар нэг байдлаар мэдэгдэхийг хориглоно.

ДӨРӨВ. БЭЛЭН МӨНГӨНИЙ ГҮЙЛГЭЭГ МЭДЭЭЛЭХ

4.1. Мэдээлэх үүрэгтэй этгээд нь дараахь гүйлгээг бэлэн мөнгөний гүйлгээний тайлангийн дагуу ажлын 7 өдрийн дотор Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ:

4.1.1. 20 сая төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/ буюу түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний гүйлгээ;

4.1.2. Ажлын нэг өдрийн дотор хийсэн хоорондоо холбоо бүхий хэд хэдэн удаагийн бэлэн мөнгөний гүйлгээний дүн 20 сая төгрөгөөс бага боловч, нийт үнийн дүн нь 20 сая төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/ буюу түүнээс дээш үнийн дүнтэй гүйлгээг бэлэн мөнгөний гүйлгээний тайлангийн дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ;

4.1.3. 20 сая төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/ буюу түүнээс дээш үнийн дүнтэй гадаад төлбөр тооцоо бүрийг гадаад төлбөр тооцоо, гүйлгээний тайлангийн дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ;

4.1.4. 20 сая төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/ буюу түүнээс дээш үнийн дүнтэй гүйлгээ боловч сэжигтэй гүйлгээ бол бэлэн мөнгөний гүйлгээний тайлангийн зэрэгцээ сэжигтэй гүйлгээний тайлангийн дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ.

4.1.5. 20 сая төгрөгөөс бага боловч сэжигтэй гүйлгээ илэрвэл данстай харилцагчийн тухай данс нээх үеийн мэдээлэл, дансгүй харилцагчийн тухай мэдээлэх үүрэгтэй этгээдэд хадгалагдаж буй албан ёсны баримт бичиг, орлого, зарлага, гуйвуулгыг мэдээлэх үүрэгтэй этгээдийн өөрийн маягт (мэдүүлэг, ордер, шилжүүлэг, төлбөрийн даалгавар гэх мэт) дээр түүний бичсэн мэдээлэл болон мэдээлэх үүрэгтэй этгээдэд байгаа тухайн харилцагчийн тухай боломжтой бүх мэдээллийн эх үүсвэрт үндэслэн сэжигтэй гүйлгээний тайланг бөглөж Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ.

ТАВ. СЭЖИГТЭЙ БОЛОН БЭЛЭН МӨНГӨНИЙ ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАНГ МЭДЭЭЛЭХ АРГА ХЭЛБЭР

5.1. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих ажилтан сэжигтэй гүйлгээний тайлан, бэлэн мөнгөний гүйлгээний тайланг факс, цахим хэлбэрээр эсхүл бичгээр нууцлал, аюулгүй байдлыг хангаж Санхүүгийн мэдээллийн албанд дараахь байдлаар мэдээлнэ.

5.1.1. Сэжигтэй гүйлгээний тайлан, бэлэн мөнгөний гүйлгээний тайланг цахим хэлбэрээр ирүүлбэл, мэдээллийн төрөл, ангилал, арга хэлбэрийг урьдчилж мэдэгдэх;

5.1.2. Сэжигтэй гүйлгээний тайлан, бэлэн мөнгөний гүйлгээний тайланг бичгээр ирүүлбэл, гарын үсгээр баталгаажуулж, тэдгээрийн үнэн зөв, бүрэн байдлыг хариуцах.

5.1.3. Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 11.1-д заасны дагуу харилцагчийн хийсэн буюу хийлгүүлэх гэж байгаа гүйлгээ нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх зорилготой гэж үзэх үндэслэлтэй гэж үзвэл Санхүүгийн мэдээллийн албанд тухайн гүйлгээг түдгэлзүүлэх шийдвэр гаргаж мэдээлэх үүрэгтэй этгээдэд бичгээр, тийм боломжгүй бол утсаар 24 цагийн дотор мэдэгдэх бөгөөд хэрэв утсаар мэдэгдсэн бол түүнийгээ нэн даруй факс буюу бичгээр баталгаажуулна. Гүйлгээг түдгэлзүүлэх хугацаа ажлын 3 өдрөөс хэтрэхгүй байна.

5.2 Мэдээлэх үүрэгтэй этгээд нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, тогтоомжийн дагуу сэжигтэй гүйлгээний тайлан, бэлэн мөнгөний гүйлгээний тайланд дурдсан мэдээллийг хуулийн байгууллагаар шалгуулах шаардлагатай гэж үзвэл, холбогдох хуулийн байгууллагад шилжүүлэх ба Санхүүгийн мэдээллийн албанд нэг хувийг хүргүүлнэ.

ЗУРГАА. МЭДЭЭЛЛИЙН НУУЦЛАЛ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ, ХАДГАЛАХ

6.1. Сэжигтэй гүйлгээний тайлан, бэлэн мөнгөний гүйлгээний тайланг бэлтгэх, шилжүүлэх, гүйлгээг тусгайлан хянах, түдгэлзүүлэх тухай мэдээлэл, тэдгээрийн хуулбарыг нууцын тухай хууль тогтоомжийн дагуу чанд хадгална.

6.2. Сэжигтэй гүйлгээний тайлан, бэлэн мөнгөний гүйлгээний тайланг бэлтгэх, шилжүүлэх, гүйлгээг тусгайлан хянах, түдгэлзүүлэх тухай мэдээлэл, тэдгээрийн хуулбарт нэвтрэх эрхийг зөвхөн Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих ажилтан олгоно.

6.3. Сэжигтэй гүйлгээний тайланг мэдээлсэн, түүнтэй танилцсан ажилтанд дараахь үйл ажиллагааг хориглоно:

6.3.1. Хууль тогтоомжийн дагуу харилцагч өөрөө мэдээлэхийг зөвшөөрсөн хувь хүн, хуулийн этгээдэд харилцагчийн гүйлгээний талаар мэдээлэх;

6.3.2. Сэжигтэй гүйлгээний тайлан болон бэлэн мөнгөний гүйлгээний тайланг мэдээлсэн, мэдээлэх гэж байгаа тухай хууль тогтоомжийн дагуу эрх олгогдсон байгууллагын албан ёсоор томилогдсон албан тушаалтнаас өөр хувь хүн, хуулийн этгээдэд мэдээлэх;

6.3.3. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу тусгайлан хянах гүйлгээ, дансыг хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллагын албан ёсоор томилогдсон албан тушаалтнаас өөр хувь хүн, хуулийн этгээдэд мэдээлэх;

6.3.4. Санхүүгийн мэдээллийн албанаас түдгэлзүүлсэн гүйлгээний тухай хууль тогтоомжийн дагуу эрх олгогдсон байгууллагын албан ёсоор томилогдсон албан тушаалтнаас өөр хувь хүн, хуулийн этгээдэд мэдээлэх.

6.4. Мэдээлэх үүрэгтэй этгээд нь харилцагчийн гүйлгээтэй холбогдох материалыг 5-аас доошгүй жилийн хугацаанд хадгална.

6.5. Мэдээлэх үүрэгтэй этгээд нь харилцагчийн нэр хаягийг тогтоосон баримт, данс бүртгэлийн болон бичиг хэргийн харилцааны талаарх мэдээллийг холбогдох данс хаагдсанаас эсвэл гэрээ дуусгавар болсноос хойш 5 жилээс доошгүй хугацаанд хадгална.

ДОЛОО. МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГТЭЙ ЭТГЭЭДИЙН ДОТООД ХЯНАЛТ

7.1. Мэдээлэх үүрэгтэй этгээд нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх арга хэмжээний хүрээнд дотоод хяналтын хөтөлбөрийг баталж мөрдөх бөгөөд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод журам”-ын хэрэгжилтийг хариуцах, байнгын хяналт тавих үүрэг бүхий ажилтныг томилж ажиллуулна. Хэрэгжилт хариуцсан ажилтны овог, нэр, албан тушаал болон холбоо барих хаягийг хэрэгжилт хариуцсан ажилтнаар томилсон тушаалын хувийн хамт Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албанд хүргүүлнэ.

7.2. Мэргэжлийн байгууллагын дотоод хяналтын хөтөлбөрт дараахь зүйлийг тусгана:

7.2.1. Тус байгууллагын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод журам,

7.2.2. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон түүнтэй холбогдуулан гарсан журам, тус байгууллагын дотоод журмын хэрэгжилтэд хяналт тавих ажилтныг томилох, чөлөөлөх журам, түүний эрх үүрэг,

7.3. Мэдээлэх үүрэгтэй этгээд нь хэрэгжилт хариуцсан ажилтнаар хэнийг томилсон болон түүнтэй холбоо барих утас, и-мэйл хаяг зэргийг Санхүүгийн мэдээллийн албанд мэдэгдэнэ.

7.4. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих ажилтан сэжигтэй гүйлгээний төрлүүд, тэдгээрийг илрүүлэх арга, хэлбэр, сэжигтэй гүйлгээний тайланг бөглөх, мэдээлэх, дамжуулах талаар мэдээлэх үүрэгтэй этгээдийн удирдлага, ажилтнуудад жилд нэгээс доошгүй удаа сургалт зохион байгуулна.

7.5. Энэ журмын 7.1-д заасан хөтөлбөр болон мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр батлагдсан дотоод журам, заавар, тэдгээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг Монголбанкны Санхүүгийн мэдээллийн алба болон Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 5 хоногийн дотор хүргүүлэн бүртгүүлж байна.

7.6. Мэдээлэх үүрэгтэй этгээдийн хэрэгжилт хариуцсан ажилтан нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хийсэн ажлын тайлангаа мэдээлэх үүрэгтэй этгээдийн төлөөлөн удирдах зөвлөл болон хувь нийлүүлэгчид улирал тутам тайлагнаж, төлөөлөн удирдах зөвлөл болон хувь нийлүүлэгчийн танилцаж гарын үсэг зурсан тайлангийн хувийг Санхүүгийн мэдээллийн албанд ирүүлж байна.

7.7. Мэргэжлийн байгууллагад дараахь үйл ажиллагааг хориглоно:

7.7.1. Нэргүй, эсхүл хуурамч болон дугаарласан нэрээр данс нээх, гүйлгээ хийх, хаагдсан данс ашиглах,

7.7.2. Гадаад улсад бүртгэгдсэн гэх боловч биетээр оршдоггүй, тухайн орны санхүүгийн зохицуулалтад үл хамаарах банк, санхүүгийн байгууллага болон тэдгээртэй харилцдаг, банк, хуулийн этгээдтэй харилцаа тогтоох.

7.7.3. “НҮБ-ын тогтоолоор террорист гэж зарлагдсан байгууллага, этгээдийн нэрсийн жагсаалтыг гаргах, мэдээлэх, тэдгээрийн гүйлгээг түдгэлзүүлэх тухай журам”-ын дагуу уг жагсаалтад нэр нь орсон этгээдэд үйлчилгээ үзүүлэх, хамтран ажиллахыг хориглоно. Хэрэв жагсаалтад дурдагдсан этгээд болох нь тогтоогдвол Санхүүгийн мэдээллийн албанд 24 цагийн дотор мэдэгдэнэ.

НАЙМ. ХАРИУЦЛАГА

8.1. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО